



Сайн байцгаана уу. Эрхэм хүндэд багш нараа. Миний бие 2018 онд Япон улсад болсон хичээлийн судалгааны сургалтад хамрагдсан Б.Ариунзул байна. Энэхүү сургалтад хамрагдсан сэтгэгдлээсээ хуваалцахад таатай байна. Хамгийн эхлээд боловсролын яамны музей үзэхэд асар их тэвчээр хүчин зүтгэлийн үр дүн энэ өндөр боловсролын системийг бий болгосныг ойлгосон.

Ялангуяа он цагийг харуулсан богино хэмжээний киноноос агуу зүйлийн ард асар их хөдөлмөр байдаг юм гэдгийг харсан.

Батари Фүмико багшийн математикийн хичээлийн судалгаанаас би өөрийгөө “Хэт өндөр түвшинд хичээлээ шахаж, мэдээлэл дамжуулах үүднээс зааж байгаа маань алдаа юм байна. Цаашид хичээлийг хүүхдэд зориулж, удаан ч гэсэн эрдэм болгож үлдээж заах хэрэгтэй” гэж ойлгосон.

Минато дүүргийн боловсролын газартай танилцахад их өндөр хариуцлагатай ажилладаг, багшийг шалгах дүгнэх биш, багш сурагчдын төлөө үргэлж дэмжиж, тусалж ажилладаг нь таалагдсан. Манай боловсролын удирдлага ийм хэмжээнд хэзээ хүрч ажиллах бол гэсэн бодол ч төрсөн.

Широганэ сургуулийн үйл ажиллагаатай танилцахад хамгийн сүүлийн үеийн техник, тохижилт бүгд хүүхдийн төлөө байгаа нь бахархмаар сэтгэгдэл төрүүлсэн. Ёстой тэнд л хүүхэд хөгжих бүрэн бололцоог хангасан байсан. Бидэнд зориулж хөгжим тоглож өгсөнд маш их баярласан.

Батари багшийн байгалийн ухааны хичээлд сууж үзэхэд үнэхээр их таалагдсан. Хэт яруу биш, хүүхэд төвтэй авах зүйл ихтэй хичээл болсон.

Багш бэлтгэх их сургуулийн дэргэдэх лицей сургуульд очиход багш нарыг найрсаг зан, хүүхдүүдийн сэргэлэн цовоо хэлэх гэсэн зүйлээ шууд хэлдэг байдал их таалагдсан. Тэнд ажиглалт хийсэн байгалийн ухаан, математикийн хичээл үнэхээр сайн хичээл байсан.

Япон улсын боловсролын систем манайх шиг багш өөрөө хий гээд судлагдахууны нэрс гаргаад хаядаг биш, яамнаасаа багш хүртэл бүгд холбоотой нэг чиглэлээр ажиллаж, ижил нэгж, ээлжит хөтөлбөрөөр зааж байгаа нь хүүхдэд ялгавартай биш жигд хөгжих боломж олгож байна.

Японы NPO буюу хичээлийн судалгааны нийгэмлэг нь миний ирээдүйн зорилготой ижил ч гэсэн их удаан хугацаа шаардагдах гэдгийг ойлгосон гэхдээ хэзээ ч зорилгоосоо ухрахгүй. Ийм сайхан буянтай ажил эхлүүлж буй Та бүхний цаашдын ажил үйлс бүтэмжтэй байг.

МУИС-ийн “Байгаль эх” Лицей сургуулийн математикийн багш
Бадарч овогтой Ариунзул



Монголын Хичээлийн Судалгааны Нийгэмлэгээрээ дамжуулан суралцахуйн болон багшлахуйн арга зүйгээс суралцах, харилцан туршлага солилцох, судалгааны арга зүйгээр илтгэл бичих, унших зэрэг ажлын байран дээрээ болон бүс, үндэсний хэмжээнд хөгжин боловсорч байдагтаа их баяртай байдаг.

Саяхан 2018.05.30- 06.06 ны хооронд бидний 15 нөхөд " Японы боловсролын тогтолцоо, сургуулийн үйл ажиллагаатай танилцах, хичээлийн судалгааны өдөрлөгт оролцрх" хөтөлбөрийн дагуу Япон оронд зочлоод ирлээ. Өндөр хөгжил, соёлтой харилцаа, боловсролын зөв чиг хандлагаараа дэлхийд дээгүүр бичигдэх тус оронд богинохон хугацаанд ч болов зочлоод их зүйлийг олж мэдэж, аяны богц маань дүүрэн ирсэндээ сэтгэл ханамжтай байна.

Өмнө 2003 онд "Залуучуудын найрамдлын хөтөлбөр"-т оролцон 24 хонож байлаа. Иймд Япон орон миний 2 дахь эх орон минь юм шиг л санагддаг. Япон ард түмний найрсаг харилцаа, хүнийг хүндэтгэх чадвар нь дэндүү бишрэлтэй. Ингээд олон зүйлийг нуршилгүйгээр миний сэтгэлийг татсан олон зүйлийн нэгээхэн хэсгийг бичье.


Бид 06.04-ний өдрийн хөтөлбөрийн дагуу Минота дүүргийн Сэйнэн бага сургууль болон Сэйнэн цэцэрлэгийн үйл ажилллагаатай танилцаж Тэраши багшийн байгалийн ухааны хичээлд суун хэлэлцүүлэг хийлээ. Мөн тус сургуулийн 5-р ангийнхантай хамт үдийн хоол идсэн нь сонирхолтой бөгөөд хөгжилтэй байлаа. Тэр өдрийн жижүүр болтой 2 охин 2 хүү жигдхэн цагаан (тогоочийн) өмсгөл өмсөөд л хоолоо аягалаад л...



Тэраши багш маань 30 гаруй жил ажилласан, байгалийн ухааны мэргэжлийн багш юм байна. Төрөл бүрийн үр, түүн доторх цардуулын хэмжээг тогтоох хичээлийг туршилтаар харууллаа. . Хүүхдүүд маань хэрэглэгдэхүүн болон техник хэрэгсэлтэй харьцаж байгаа, ажигласан зүйлээ тэмдэглэн бичиж байгаа, хичээлд мэдэхийн төлөө оролцож, эргэлзээтэй зүйлийг өөрөө явж бусдаас мэдэж авч байгаа (Монголд бол жаахан үймүүлэх зүйл гаргаж магадгүй) зэрэг үйлүүд нь бүр хэвшил болохоос гадна "би хийх ёстой" гэсэн сэтгэлтэй байгаа нь харагдсан.

Хичээлийн дараах хэлэлцүүлэгт бидний саналыг сонсож хуваалцаж бас асуултанд хариулж байгаа нь энгийн бөгөөд сэтгэл шингэсэн. Их таалагдсан шүү.

Бас тэр өдрийн нэг онцлог баярт зүйл гэвэл "Дүүргийн боловсролын хэлтэс"-ээс мзогэжилтнүүд ирж тэр сургууль дээр бидэнтэй хамт ажилласан явдал байлаа. Жилдээ нэг сургууль дээр 10 удаа зөвлөн тусалдаг ба энэ удаагийнх нь яг бидний хөтөлбөртэй давхцаж байсан нь аз тохиосон юм.



**Япон улсын Токио хотод зохион байгуулагдсан
“Хичээлийн судалгааны онол, арга зүй” сэдэвт
сургалтаас төрсөн миний сэтгэгдэл**

Юуны өмнө МХСН-ийн хамт олон, гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэг, орчуулга хийсэн багш Г.Норжмаа болон нэгэн зорилгын дор нэгдэж баг болон явсан мэргэжил нэгт багш, сургалтын менежерүүд болон японы NPO, Сүзүки нартаа маш их баярласнаа илэрхийлье!



“Хичээлийн судалгааны онол, арга зүй” сэдвийн хүрээнд Япон улсад сургалтанд хамрагдаж тус улсын боловсролын, тогтолцоо, сургуулийн менежмент, үйл ажиллагаа, судалгаат хичээл ажиглалт, хэлэлцүүлэг, багш нарын арга зүй, японы соёл, урлагтай танилцаж туршлага судалсан нь миний хувьд маш том амжилт байлаа. Цаашид хийж хэрэгжүүлэх олон сайхан шинэлэг санаа, арга зүйг олж харж, сурч авсандаа баяртай байна.

Үүнд:

1. Япон багш нар үйл ажиллагаандаа судалгаатай ханддаг.
2. Хөдөлмөрлөж судалж, үр дүнг нь харахыг хичээдэг, харж чаддаг.
3. Хүүхдийг багаас нь эмх цэгцтэй байдалд сургаж чаддаг
4. Сургуулийн гадна, дотор орчинг энгийн зүйлээр шийдсэн.

5. Сурагчдын хийсэн бүх бүтээл болон хичээлийн дүгнэлт зэргийг анги танхим, коридорт тухай бүр нь гаргаж байршуулдаг.
6. Багш нар хамтарч арга зүйгээ дээшлүүлэх бусдаас суралцах зүйл их байна.
7. Сургууль, багш, сурагчийн зорилго нь уялдаа холбоотой бөгөөд биелэгдэхүйц, үнэлэгдэхүйц байж чаддаг
8. Самбар ашиглалт – эмх цэгцтэй, ойлгомжтой
9. Дэвтрийн үйл ажиллагаа, 2 төрлийн үнэлгээ нь ойлгомжтой, бодитой, зорилгоо дэмжсэн
10. Багш, сурагчийн олон өнгийн бал, шохой хэрэглэж байгаа нь цаг хэмнэсэн, ойлгомжтой, уялдаатай
11. Хүүхэд үнэт эрдэнэ гэж дээдэлдэг нь үнэхээр сайхан санагдлаа.

Хичээлийн судалгаагаар мэргэших , судлаач байх зорилгыг өөртөө тавьж байна.

Сэтгэгдлээ бичсэн: Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын бүрэн дунд сургуулийн сургалтын менежер Т.Пүрэвцагаан

2018.06.12

МИНАТО хичээлийн судалгааны академи NPO



Минато дүүргийн энэхүү байгууллага нь сургуулийн захирал, БГ дарга, цэцэрлэгийн эрхлэгч, зөвлөх багш нараас бүрдсэн БАГШ нарынхаа ур чадварыг хэрхэн дээшлүүлэх тал дээр ажилладаг, зөвлөгөө өгдөг, тусалдаг, дэмждэг, урам хайрладаг академи байна.

Энэхүү академи нь 2006 онд байгуулагдсан ба доорхи 3 үүргийг гүйцэтгэдэг.

1. Хичээлийн төлөвлөлтийг сайжруулахад

Энэ бол багш бид нарт хамгийн чухал зүйл. Хэдийн чинээ сайн төлөвлөж хичээлээ орно төдий чинээ хичээл маань үр дүнтэй болно гэж би бодож байна. Хичээл төлөвлөлтөнд хэрэглэгдэхүүн чухал байр суурь эзэлдэг. Хүүхдийн анхаарлыг яаж татах вэ, нас сэтгэхүйн онцлогт нь тохирч байна уу, харагдах өнцөг нь ямар байна зэрэг олон онцлогтой.

Мөн хичээл төлөвлөлтөнд зорилгоо тодорхойлно, стандарттай тохирсон үнэлгээ байна, шалгуураа төлөвлөнө. Арга зүйн төлөвлөлт нь хичээлийн гол баганын нэг, ямар хэлбэрээр явуулах гэх мэт. Ээлжит хичээлийн хөтөлбөрөө боловсруулна. Энэ бүхэн дээр энэ академийн гишүүн тусална. Ганцаарчилсан арга зүйгээр тусална.

2. Багшийн арга зүйг сайжруулна. Жишээ нь хүүхдүүдээ бүлгээр ажиллуулна.

- дэмжлэг шаардлагатай хүүхдүүд
- хурдтай хүүхдүүд гэх мэт ангиа хуваагаад хамтын хичээл заана.

3. Хүүхдэд хандах хандлага

Энд багш, эцэг эх, хүүхдийн гурвалсан холбоо хамгийн чухал. Сургууль нь багаар ажиллаж байж үр дүнд хүрнэ, соёлд суралцана. Нэг бүлэгт орж байгаа багш нар хамтарч ажиллана гэнэ.

Залуу багш нартайгаа ахмад багш нар нь хамтарч ажилладаг. Хичээл дээр нь сууж ажиглалт хийж байж зөвлөгөө өгдөг. Нэг багшид 4 удаа орчим зөвлөгөө өгдөг. Хичээл зааж үзүүлдэг \ Арга зүй, хүүхдийн харилцаа, хэрэглэгдэхүүн\.

Хичээлийн бэлтгэл судалгаанд зөвлөгөө өгнө. Өөрийн гарын авлагаа үзүүлдэг. Хамтран төлөвлөгөө боловсруулдаг. Жишээ нь хүүхдэд ямар даалгавар өгөх гэж байгаа, ямар асуулт асуух гэж байгаа, хүүхэд юу гэж хариулах бол гэх мэт зүйлсийг асуудаг.

Бусад багш нар дээрээ туршилт хийж болно. Академийн багш нар ажиглана. Хэлэлцүүлэг явагдана. Дараа нь зөвлөх багш нь ганцаараа үлдээд залуу багштайгаа хамтран засан сайжруулалтаа хийнэ. Урам өгнө. Эдгээр багш нар маань цагт баригддаггүй. Хээ ч туслахад бэлэн байдаг.

Сард нэг удаа, бямба гарагт болон үдээс хойш тусалдаг. Залуу багш нар маань туршилтын хичээлээ өөрсдөө заагаад, ангийн дэгээ боловсруулаад, хүүхдүүдээс асуух асуултаа бэлдээд, хүүхдүүдээ үүрэгжүүлээд асууна. Саналаа солилцоно. Харилцан ярилцах боломж бүрдүүлнэ. Итгэнэ. Урам зориг өгнө.

Энэ бүхэн үнэхээр сайхан санагдсан. Зарим үед залуу багш бид нарт тусламж хэрэгтэй үе олон байдаг. Гэтэл бидэнд хэзээ хэрэгтэй үед туслах завтай хүн байдаггүй.

Ямар л тусламж дэмжлэг хэрэгтэй байна тусалдаг, тэр бүү хэл багшлах эрхийн шалгалт өгөхөд ч тусалдаг байгууллага байна.

Минато дүүргийн NPO –н багш нартаа эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!”



Хөвсгөл аймгийн Дэлгэр мөрөн ЦС-ийн багш Л. Хажидмаа